



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Дөрвөн -Оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/161/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:gonchigdorjuranbayr@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.22 № 96

танай _____ -ны № _____ -т

УЛИАСТАЙ СУМЫН ДӨРВӨН
ОНОО ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.ОТГОНЧИМЭГ-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 55.4 сая төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 482.2 сая төгрөг нийт 537.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу бүртгэж, элэгдэл буруу тооцоолсон, хөрөнгийн шинжтэй зүйлсийг бараа материалд бүртгэсэн зэрэг алдаа илэрлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГӨӨСӨХ
АУДИТОР  Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,983,919.77</u>	<u>68,924,470.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,074,105.91	66,024.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,074,105.91	66,024.51
3121	Төгрөг	1,074,105.91	66,024.51
31211	Төрийн сангийн харилцах	1,074,105.91	66,024.51
33	АВЛАГА	-	20,439,969.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	20,439,969.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,909,813.86	48,418,476.62
351	Түүхий эд материал	28,022,779.86	26,779,873.62
35130	Эм боох материал	28,022,779.86	26,779,873.62
354	Хангамжийн материал	15,887,034.00	21,638,603.00
35410	Бичиг хэргийн материал	1,463,000.00	2,689,069.00
35420	Аж ахуйн материал	13,102,400.00	14,738,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	225,000.00	2,385,000.00
35450	Барилгын засварын материал	25,000.00	754,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,071,634.00	1,071,634.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>72,418,077.48</u>	<u>76,689,763.35</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	72,418,077.48	76,689,763.35
392	Биет хөрөнгө	72,418,077.48	76,689,763.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,600,000.00	31,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,499,999.92)	(12,933,333.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,978,687.18	115,878,687.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,030,888.58)	(66,160,764.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,299,893.28	16,549,893.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,929,614.48)	(8,244,719.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,186,909.09	3,186,909.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,186,909.09)	(3,186,909.09)
39301	Програм хангамж	320,000.00	320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(320,000.00)	(320,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>117,401,997.25</u>	<u>145,614,233.48</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>7,400,445.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,400,445.00
413	Өглөг	-	7,400,445.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,166,355.00
4136	Бусад өглөг	-	4,234,090.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,234,090.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>117,401,997.25</u>	<u>138,213,788.48</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	117,401,997.25	138,213,788.48

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,036,652.00	17,036,652.00
51101	Өмч: - төрийн	17,036,652.00	17,036,652.00
512	Хуримтлагдсан үр дүн	93,664,208.25	114,475,999.48
51210	Өмнөх үеийн үр дүн	93,664,208.25	93,664,208.25
51220	Тайлант үеийн үр дүн	-	20,811,791.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,701,137.00	6,701,137.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	117,401,997.25	145,614,233.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	635,159,319.29	560,115,241.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,470,859.29	22,415,543.76
120	Нийтлэг татварын бус орлого	22,470,859.29	22,415,543.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,310,859.29	22,415,543.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,310,859.29	22,415,543.76
120009	Бусад орлого	160,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	612,688,460.00	537,699,697.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,912,500.00	482,229,628.42
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	412,912,500.00	482,229,628.42
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,773,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,773,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	197,002,960.00	55,470,069.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	197,002,960.00	55,470,069.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	637,910,244.57	539,303,449.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,910,244.57	539,303,449.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,605,245.57	535,661,599.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,746,032.00	383,900,292.00
210101	Үндсэн цалин	423,746,032.00	383,900,292.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,300,332.07	47,555,407.32
210201	Тэтгэврийн даатгал	36,018,413.00	32,199,397.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,237,460.00	3,839,003.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,389,968.00	3,071,202.00
210204	Ажилгүйдлийн даатгал	847,492.00	767,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,806,999.07	7,678,005.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,074,881.00	1,699,623.50
210301	Гэрэл, цахилгаан	525,971.00	626,923.50
210303	Цэвэр, бохир ус	1,548,910.00	1,072,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,981,427.00	20,524,000.00
210401	Бичиг хэрэг	3,768,390.00	3,697,350.00

210402	Тээвэр, шатахуун	5,148,280.00	4,706,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,457,357.00	3,676,700.00
210404	Ном, хэвлэл	23,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,915,100.00	2,371,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,800.00	3,920,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,562,200.00	2,151,150.00
2105	Нормативт зардал	72,996,095.70	36,614,305.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,996,095.70	36,614,305.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,769,350.00	4,525,350.00
210604	Урсгал засвар	3,769,350.00	4,525,350.00
2107	Томилолт, зочны зардал	9,531,964.00	10,685,100.00
210702	Дотоод албан томилолт	9,281,964.00	10,685,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	250,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,441,014.00	3,476,431.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	725,000.00	1,560,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	964,000.00	1,110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.00	99,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,848.00	80,816.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,000.00	528,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	111,666.00	98,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,764,149.80	26,681,091.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,500.00	41,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,783,120.00	3,761,777.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,965,529.80	22,878,314.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,304,999.00	3,641,850.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,304,999.00	3,641,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,304,999.00	3,641,850.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(2,750,925.28)</u>	<u>20,811,791.23</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,750,925.28)</u>	<u>20,811,791.23</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>661,384,140.00</u>	<u>517,259,728.42</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	160,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	160,000.00	-
120009	Бусад орлого	160,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	661,224,140.00	517,259,728.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,912,500.00	482,229,628.42

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	412,912,500.00	482,229,628.42
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,308,680.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,773,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	197,002,960.00	35,030,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	197,002,960.00	35,030,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	623,365,090.57	505,917,809.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	623,365,090.57	505,917,809.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,060,091.57	503,532,609.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,746,032.00	380,733,937.00
210101	Үндсэн цалин	423,746,032.00	380,733,937.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,651,063.07	47,555,407.32
210201	Тэтгэврийн даатгал	35,369,144.00	32,199,478.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,237,460.00	3,839,003.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,389,968.00	3,071,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	847,492.00	767,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,806,999.07	7,678,006.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,074,881.00	1,557,623.50
210301	Гэрэл, цахилгаан	525,971.00	626,923.50
210303	Цэвэр, бохир ус	1,548,910.00	930,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,336,247.00	22,384,469.00
210401	Бичиг хэрэг	4,533,690.00	3,921,919.00
210402	Тээвэр, шатахуун	5,140,000.00	4,706,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,457,357.00	3,676,700.00
210404	Ном, хэвлэл	23,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,915,100.00	2,371,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,445,500.00	5,000,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,821,300.00	2,707,250.00
2105	Нормативт зардал	72,978,920.50	25,040,415.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,068,920.50	25,040,415.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,910,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,501,350.00	7,414,950.00
210604	Урсгал засвар	3,501,350.00	7,414,950.00
2107	Томилолт, зочны зардал	9,531,964.00	10,685,100.00
210702	Дотоод албан томилолт	9,281,964.00	10,685,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	250,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,441,014.00	3,356,431.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	725,000.00	1,440,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	964,000.00	1,110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.00	99,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,848.00	80,816.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,000.00	528,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	111,666.00	98,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,798,620.00	4,804,277.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,500.00	41,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,783,120.00	4,763,277.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,304,999.00	2,385,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,304,999.00	2,385,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,304,999.00	2,385,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>38,019,049.43</u>	<u>11,341,918.60</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,963,300.00	12,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,963,300.00	12,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,963,300.00	12,350,000.00
222001	Тоног төхөөрөмж	32,450,300.00	11,100,000.00
223001	Бусад хөрөнгө	4,513,000.00	1,250,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(36,963,300.00)</u>	<u>(12,350,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,055,749.43	(1,008,081.40)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,356.48	1,074,105.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,074,105.91	66,024.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,036,652.00	6,701,137.00	93,664,208.25	117,401,997.25
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,036,652.00	6,701,137.00	93,664,208.25	117,401,997.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,036,652.00	6,701,137.00	93,664,208.25	117,401,997.25
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	20,811,791.23	20,811,791.23

D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,036,652.00	6,701,137.00	114,475,999.48	138,213,788.48
-----	---------------------------------------	---------------	--------------	----------------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,492,000.00	473,859,465.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,492,000.00	473,859,465.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,692,000.00	472,329,265.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,000,000.00	385,352,709.00
210101	Үндсэн цалин	384,000,000.00	385,352,709.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,000,000.00	31,834,587.00
210201	Тэтгэврийн даатгал	48,000,000.00	31,834,587.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,800,000.00	1,111,414.50
210301	Гэрэл, цахилгаан	600,000.00	525,034.50
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	586,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,800,000.00	17,720,300.00
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	2,987,450.00
210402	Тээвэр, шатахуун	5,600,000.00	4,299,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,676,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,080,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,200,000.00	4,320,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,000,000.00	1,355,550.00
2105	Нормативт зардал	25,000,000.00	13,361,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,000,000.00	13,361,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	8,402,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	4,600,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	3,802,600.00
2107	Томилолт, зочны зардал	11,000,000.00	9,741,100.00
210702	Дотоод албан томилолт	11,000,000.00	9,741,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,432,000.00	1,358,956.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	360,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	555,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,816.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	148,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	80,000.00	76,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	88,440.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,660,000.00	3,446,369.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	660,000.00	122,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	3,323,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,800,000.00	1,530,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,800,000.00	1,530,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	1,530,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	529,029,629.42	477,065,289.42
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	482,229,629.42	474,582,889.42
131001	Улсын төсвөөс санхүүжих	482,229,629.42	474,582,889.42
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,800,000.00	2,482,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	46,800,000.00	2,482,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,074,105.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	66,024.51
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрхэм зорилго: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй чанартай үзүүлэх, Чиг үүрэг: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Халдварт өвчний үндэсний хөтөлбөр, Халдварт бус өвчний үндэсний хөтөлбөр, Эрүүл хүүхэд эрүүл шүд, Эх, нялх балчир хүүхдийн эрүүл хүүхэд зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөр, Хоол тэжээлийн үндэсний дэд хөтөлбөр, Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих үндэсний хөтөлбөр, Ажилтны нийгмийн хамгааллын дэмжих үндэсний хөтөлбөр, Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл

ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЭМТ-ийн дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Дөрвөн -Оноо өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Дөрвөн -Оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,212.30 мянган төгрөгөөр буюу 24 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Бараа материал	43,909.80	48,418.50	4,508.70
Үндсэн хөрөнгө	72,418.10	76,689.70	4,271.60
Нийт хөрөнгө	117,401.90	145,614.20	28,212.30
Өр төлбөр	-	7,400.40	7,400.40
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	117,401.90	138,213.70	20,811.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	117,401.90	145,614.20	28,212.30

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 43,909.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 52,508.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй 7,615.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсан 55,615.5 мянган төгрөг, акталсан бараа материал байхгүй бараа материалын эцсийн үлдэгдэл 48,418.50 мянган төгрөг болж өмнөх оноос 4,508.70 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 14,350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 12,800.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, актласан үндсэн хөрөнгө байхгүй байна. Жилийн эцэст 76,689.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 22,878.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 20,811.80 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 537,699.60 мянган төгрөгөөр зарлагыг тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 537,699.60 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517,259.70 мянган төгрөг буюу 96,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71601	Нийгмийн эрүүл мэнд				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	537,699.60	517,259.70	20,439.90	96,2%
	Дүн	537,699.60	517,259.70	20,439.90	
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
71601	Анхан шатны эрүүл мэндийн ү/а				
	НИЙТ	537,699.60	517,259.70	20,439.90	96,2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
Шууд гэрээ байгуулах	Түлш шатахуун	5,000.00	4,706.80
Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	600.00	626.90
Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	1,200.00	885.70
Шууд гэрээ байгуулах	Эм эмнэлгийн хэрэгсэл	25,000.00	25,040.40
Шууд гэрээ байгуулах	Аж ахуйн материал	2,800.00	2,707.20
Шууд худалдан авалт	Урсгал засвар	8,000.00	7,414.90
Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	3,700.00	3,676.70
Шууд худалдан авалт	Бичиг хэрэг	4,000.00	3,921.90
Шууд худалдан авалт	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ	5,000.00	4,763.30
ДҮН		55,300.00	53,743.80

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улиастай сумын Дөрвөн -Оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Дөрвөн -Оноо өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 10 -ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 257,850.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,867.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,900.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 29 зүйл заалтаар хяналтыг хэрэгжүүлсэн ба алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Дөрвөн-Оноо өрхийн Эрүүл мэндийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,434.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 601.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг хугацаанд барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	601.6	1	601.6	100
Албан шаардлага	2	21,434.0	2	21,434.0	100
Нийт дүн	3	22,035.6	3	22,035.6	

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг тодохойлоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,600.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 7,600.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

Залруулсан : Үндсэн хөрөнгө орлого авахдаа ашиглах жил буруу сонгосон 7,600.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Төлбөрийн акт байхгүй

5.4 Зөвлөмж хүргүүлээгүй

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Дүн		Дүн		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгө орлого авахдаа ашиглах жил буруу сонгосон	1	7,600.0							1	7,600.0				
Дүн	1	7,600.0							1	7,600.0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22

Handwritten signature 1